



**ДОРНОГОВЬ АЙМАГ
ХӨВСГӨЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2019 оны 06 сарын 26 өдөр

Дугаар 5/05

Дорноговь аймаг, Хөвсгөл сум

Т.Ануухатанг ажлаас чөлөөлөх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.8 дахь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1.1 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч Т.Ануухатан нь өөрийн хүсэлтээр ажлаасаа чөлөөлөгдөх болсон тул хүсэлтийг үндэслэн 2019 оны 06 дугаар сарын 26-ны өдрөөс эхлэн үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

2. Нягтлан бодогч Т.Ануухатантай холбогдох эд хөрөнгө, ажилласан хугацааны амралт, цалин хөлс болон бусад санхүүгийн тооцоог хийж дуусгахыг санхүүгийн албаны дарга /У.Баярмаа /-д даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газрын дарга /Г.Заяасайхан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Н.ЭНХБАЯР



ДОРНОГОВЬ АЙМАГ
ХӨВСГӨЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 06 сарын 25 өдөр

Дугаар

А/74

Дорноговь аймаг, Хөвсгөл сум

О.Төмөртоогоо агсаны гэр бүлд хүндэтгэл
үзүүлэхэд хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.6 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын уугуул иргэн, МУ-ын Шинжлэх Ухааны гавьяат ажилтан, академич Ононгийн Төмөртоогоо нь өвчний улмаас таалал төгссөн тул түүний ар гэрт эмгэнэл илэрхийлж, хүндэтгэл үзүүлэхэд хөрөнгө зарцуулсугай.

2. Хүндэтгэл үзүүлэхэд шаардагдах 230,000 /Хоёр зуун гучин мянган/ төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гарган зарцуулахыг орон нутгийн нягтлан бодогч /Ч.Отгонжаргал/-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүүгийн албаны дарга /У.Баярмаа/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ЭНХБАЯР



ДОРНОГОВЬ АЙМАГ
ХӨВСГӨЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 05 сарын 20 өдөр

Дугаар 0/62

Дорноговь аймаг, Хөвсгөл сум

Гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.6 /а/ дахь заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 65 дугаар зүйлийн 65.1.4 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалт, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 08/07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй “Төв талбай” байгуулах ажлыг “Голомт пэйнт” ХХК-тай шууд гэрээ байгуулах эрх олгосугай.
2. Дээрх ажлыг гүйцэтгэхэд шаардагдах 26000000 /хорин зургаан сая/ төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөс гарган санхүүжүүлэхийг Санхүүгийн албаны дарга /У.Баярмаа/-д зөвшөөрсүгэй.
3. “Голомт пэйнт” ХХК-тай гэрээ байгуулан, техникийн тодорхойлолтын дагуу шаардлага хангасан ажлыг хяналт тавин гүйцэтгүүлж, хүлээн авах ажлыг зохион байгуулахыг Засаг даргын Тамгын газрын дарга /Г.Заяасайхан/-д үүрэг болгосугай.
4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч /Г.Ганболд/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ЭНХБАЯР



ДОРНОГОВЬ АЙМАГ
ХӨВСГӨЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 06 сарын 26 өдөр

Дугаар 5/06.

Дорноговь аймаг, Хөвсгөл сум

Ч.Отгонжаргалыг ажилд авч ажиллуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, 31 дүгээр зүйлийн 31.1.8 дахь заалт, Засгийн газрын 2007 оны 354 дүгээр тогтоолын 7 дугаар хавсралт, Засгийн газрын 2019 оны 24 дүгээр тогтоолын 9 дүгээр хавсралт, Байгууллагын дотоод журмын 5.1 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогчоор Чулуунбаатарын Отгонжаргалыг 2019 оны 06 дугаар сарын 26-ны өдрөөс эхлэн ажилд түр авч ажиллуулсугай.
2. Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогчоор ажиллах Ч.Отгонжаргалын сарын үндсэн цалинг ТҮ-7-1 шатлалаар 624357 /Зургаан зуун хорин дөрөв гурван зуун тавин долоон/ төгрөгөөр бодож олгохыг санхүүгийн албаны дарга /У.Баярмаа/-д зөвшөөрсүгэй.
3. Үүрэгт ажилдаа хариуцлагатай хандаж, хууль дүрмийг мөрдөж ажиллахыг /Ч.Отгонжаргал/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Н.ЭНХБАЯР